

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2025/013/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын илрүүлэлт	14
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

дддс. 03.14 № 399.

танай _____ -ны № _____ -т

“ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

“Дорнод Нийтийн Аж Ахуй” ОНӨААТҮГ нь 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 1 зорилт, 71 арга хэмжээний хэрэгжилтийг 90 хувиар тайлагнасан байна. Санхүүгийн тайланд бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

011022185

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	730,665,293.99	558,430,062.12
1.1.02	Дансны авлага	511,824,658.20	437,532,692.62
1.1.06	Бараа материал	105,674,336.09	90,258,490.38
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13,300,000.00	12,800,000.00
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	4,272,727.23	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,365,737,015.51	1,099,021,245.12
1.2.01	Үндсэн хөрөнгө	17,836,688,507.77	17,698,826,321.27
1.2.02	Биет бус хөрөнгө	3,807,937,666.61	3,804,823,666.57
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,644,626,174.38	21,503,649,987.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,010,363,189.89	22,602,671,232.96
2.1.1.01	Дансны өглөг	73,736,870.47	180,456,770.55
2.1.1.03	Татварын өр	176,790,583.82	312,827,107.01
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,758,855.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	260,286,309.29	493,283,877.56
2.1.2.01	Урт хугацаат зээл	0.00	2,856,238,054.38
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	1,449,384,807.06	1,287,418,807.06
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,449,384,807.06	4,143,656,861.44
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,709,671,116.35	4,636,940,739.00
2.3.01	Өмч: - төрийн	467,926,157.11	467,926,157.11
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,194,607,800.73	3,194,607,800.73
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	17,580,345,608.40	17,576,995,933.02
2.3.09	Хуримтлагдсан ашиг	57,812,507.30	-3,273,799,396.90
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-475,373,849.82
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	57,812,507.30	-2,798,425,547.08
2.3.11	Эздийн өмчийн дүн	21,300,692,073.54	17,965,730,493.96
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,010,363,189.89	22,602,671,232.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,789,889,078.72	5,452,472,319.69
2	Борлуулалтын өртөг	4,860,730,641.92	6,244,991,873.39
3	Нийт ашиг(алдагдал)	-70,841,563.20	-792,519,553.70
8	Бусад орлого	2,076,740,244.39	2,351,904,351.97
8.1	Орлогын дүн	2,076,740,244.39	2,351,904,351.97
10	Ерөнхий ба удирдлагын зардал	193,559,666.38	206,294,521.91
12	Бусад зардал	1,959,056,201.46	1,828,464,126.18
12.1	Зардлын дүн	2,152,615,867.84	2,034,758,648.09
17	Бусад ашиг (алдагдал)	-75,875,623.45	317,145,703.88
17.1	Олз, гарзын дүн	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-146,717,186.65	-475,373,849.82
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-146,717,186.65	-475,373,849.82
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-146,717,186.65	-475,373,849.82

“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,816,540,788.31	8,188,014,417.80
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,608,537,911.71	8,067,292,669.82
1.1.6	Бусад мөнгөн орлого	208,002,876.60	120,721,747.98
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,863,400,821.57	8,360,249,649.67
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,862,349,223.95	2,612,424,391.65
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	585,137,584.84	818,300,162.97
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,104,386,363.75	1,023,806,991.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	305,471,968.48	346,424,438.59
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	271,900,658.00	262,288,794.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	136,000,000.00	161,966,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	390,065,409.32	630,693,012.08
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,208,089,613.23	2,504,345,859.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-46,860,033.26	-172,235,231.87
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-46,860,033.26	-172,235,231.87
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	777,525,327.25	730,665,293.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	730,665,293.99	558,430,062.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	15,750,258,031.84	-1,282,801,160.43	18,129,990,829.25
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	1,487,330,854.38	1,487,330,854.38
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-146,717,186.65	-146,717,186.65
6	Өмчид гарсан	0.00	0.00	1,830,087,576.56	0.00	1,830,087,576.56
9	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	17,580,345,608.40	57,812,507.30	21,300,692,073.54
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-2,856,238,054.38	-2,856,238,054.38
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-475,373,849.82	-475,373,849.82
14	Өмчид гарсан	0.00	0.00	-3,349,675.38	0.00	-3,349,675.38
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	17,576,995,933.02	-3,273,799,396.90	17,965,730,493.96

2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2024 оны төлөвлөгөө /мян.төг/	2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэл /мян.төг/
НИЙТ ОРЛОГО		5,614,389.6	5,786,252.7
Үйл ажиллагааны орлого		5,502,889.6	5,452,470.7
1	ААНБ-д цэвэр үс түгээх үйлчилгээ	1,159,200.0	1,096,614.3

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2	Айл өрхөд цэвэр ус түгээх үйлчилгээ	1,035,829.2	982,103.1
3	Гэр хороололд цэвэр ус түгээх үйлчилгээ	120,384.0	128,430.7
4	Цэвэр усны суурь хураамж	306,009.1	311,251.9
5	ААНБ-аас бохир ус татан зайлуулах үйлчилгээ	984,480.0	889,777.7
6	Айл өрхөөс бохир ус татан зайлуулах үйлчилгээ	918,624.0	863,773.9
7	ААНБ-ийн дулаан дамжуулан түгээх үйлчилгээ	214,398.9	348,666.2
8	Айл өрхийн дулаан дамжуулан түгээх үйлчилгээ	347,291.9	349,259.9
9	ХХУ дамжуулан түгээх үйлчилгээ	123,500.4	122,674.5
10	Дулааны суурь хураамж	113,172.1	111,329.4
11	Бусад орлого	180,000.0	248,589.1
Үйл ажиллагааны бус орлого		111,500.0	333,782.0
1	Хүү, торгуулийн арга хэмжээ	61,500.0	6,680.9
2	Засвар үйлчилгээний орлого	30,000.0	19,577.7
4	Бусад	20,000.0	307,523.4
НИЙТ ЗАРДАЛ		6,628,560.3	6,261,626.5
Үйл ажиллагааны зардал		5,941,474.4	5,733,416.3
1	Цалин хөлс	3,418,626.3	3,182,134.8
2	Ажил олгогчоос олгох ЭМД, НДШ	461,514.6	419,118.9
3	Цахилгаан	382,402.0	370,450.0
4	Дулаан	27,484.5	25,908.5
5	Нүүрс	30,827.5	17,276.7
6	Тээврийн зардал	8,000.0	11,223.8
7	Шатахуун, ШТМ	261,415.9	189,637.2
8	Элэгдлийн зардал	650,000.0	780,950.0
9	Урсгал засвар	220,821.0	225,685.0
10	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардал	204,546.5	206,958.7
11	Бичиг хэрэг	4,652.0	7,949.5
12	Холбоо	27,971.1	25,057.4
13	Материал түүхий эд худалдан авах	150,000.0	144,636.0
14	Албан томилот	10,449.0	9,868.5
15	Аваарын нөөц	19,880.0	19,880.0
16	Бусад зардал	62,884.0	96,681.3
Удирдлагын зардал		211,399.5	206,294.5
1	Цалингийн зардал	103,889.0	100,018.7
2	ЭМД, НДШ-ийн зардал	14,025.0	12,778.5
3	ТУЗ-ын урамшуулал	30,240.0	39,480.0
4	ТУЗ-ын ЭМД, НДШ	4,021.9	3,432.6
5	Бичиг хэрэг	1,586.0	750.2
6	Шатахуун	8,000.0	9,780.8
7	Хөдөлмөр хамгаалал	2,355.0	1,300.0
8	Холбоо	475.2	509.6
9	Элэгдлийн зардал	27,000.0	21,029.1
10	Урсгал засвар	3,500.0	2,751.0
11	Материал түүхий эд	2,500.0	1,038.0
12	Албан томилот	6,269.4	6,089.6
13	Бусад зардал	2,500.0	1,826.9
14	ТУЗ-ын бусад зардал	5,038.0	5,509.5

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Үндсэн бус үйл ажиллагааны зардал		475,686.4	321,915.7
1	Буцалтгүй тусламж	62,200.0	58,800.0
2	Ахмадын сан	16,000.0	11,027.4
3	Шагналын сан	7,000.0	6,492.6
4	Тэтгэвэрт гарах ажилчдын тэтгэмж	142,437.1	42,063.3
5	Мэдээлэл, Зар сурталчилгаа, хэвлэл	15,000.0	15,073.0
6	Гадаад арга хэмжээ /сургалт/	25,000.0	6,090.0
7	Сургалтын зардал	19,435.0	10,717.7
8	НАА-н 55 жил үйл ажиллагаанд	50,000.0	41,362.1
9	Дотоодын цэргийн тусгай салааны зардал	16,294.3	16,154.6
10	Бусад	10,000.0	9,270.9
11	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	23,000.0	28,956.6
12	Аудитын хөлс	10,500.0	10,500.0
13	Программын лицензийн төлбөр	1,500.0	1,350.5
14	НАА-н спортын арга хэмжээ	10,000.0	9,704.2
15	Ажиллагсадын хоолны зардал	67,320.0	54,352.8
НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/Алдагдал/		(1,014,170.6)	(475,373.8)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 236,875.7 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс, 103,376.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 133,499.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгч ажиллалаа.

3.1 Төлбөрийн акт

1. “Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь 2023 онд "Санхүүгийн үйл ажиллагааны бодлогын баримт бичиг"-ийг хийлгэхээр 4.8 сая төгрөг шилжүүлэн урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн ч ажил нь одоо хүртэл дуусаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 43 дугаар зүйлийн 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Хэрлэн сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх 98.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Уг өр төлбөр нь орон сууцны айл өрх, орон сууцанд байрлах ААНБ-аас 2023, 2024 онд хураан авсан хог тээвэрлэлтийн төлбөрийг Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ, Дорнод НАА ОНӨААТҮГ, Хэрлэн сумын ЗДТГ-ын хооронд байгуулсан гэрээний дагуу Хэрлэн сумын төсвийн дансанд шилжүүлээгүйтэй холбоотой үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", байгууллага хооронд байгуулсан гэрээний 2.3 дахь "Дорнод НАА ОНӨААТҮГ нь хог тээвэрлэлтийн тухайн сард төвлөрүүлсэн орлогын 20 хувийг өөрийн байгууллагад үлдээн, 80 хувийг дараа сарын ажлын 10 хоногт багтаан Хэрлэн сумын

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төсвийн орлогын дансанд шилжүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

1. Дорнод НАА ОНӨААТҮГ нь жилийн эцсийн байдлаар нийт 437.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 23 Аж ахуйн нэгжээс авах 41.6 сая төгрөг, 483 айл өрхөөс авах 83.8 сая төгрөг нийт 125.4 сая төгрөгийн авлага нь 90 хоногоос дээш буюу хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "...дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тус байгууллага нь 2023 онд "Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил"-ыг хийлгэхээр гүйцэтгэгч компанитай 2023 оны 10 дугаар сарын 26-нд дуусгах гэрээ байгуулан 8.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна. Гүйцэтгэгч компани ажлаа дуусгасан ч холбогдох төрийн байгууллагуудаар баталгаажуулах ажлыг хамтран зохион байгуулаагүйгээс уг ажил нь хугацаандаа хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Тайлант хугацаанд зохион байгуулсан 3 удаагийн тендер тус байгууллагын захирлын тушаалаар баталсан "Үнэлгээний хороо"-ны 2 гишүүн нь тайлант хугацаанд зарласан тендер шалгаруулалтад оролцсон эсэх нь ирүүлсэн баримтаар нотлогдохгүй байна. Үүнд: Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг баталгаажуулаагүй, Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна", 51.3-т "Үнэлгээний хороо нийт гишүүний дөрөвний гурваас багагүй тооны гишүүний ирцтэй хуралдсанаар хурлыг хүчинтэйд тооцно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим системд 170 мэдээлэл оруулахаас 16 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1 дэх "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2 дахь "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.4 дэх "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

дугаар сарын 15-ны өдрийн дотор” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
"Санхүүгийн үйл ажиллагааны бодлогын баримт бичиг"-ийг хийлгэхээр төлбөрийг шилжүүлэн урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн ч ажил нь одоо хүртэл дуусаагүй байна.	1	4,800.0	1	4,800.0	-	-	-	-	-	-	-	-
Хэрлэн сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх 98.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	98,576.6	1	98,576.6	-	-	-	-	-	-	-	-
90 хоногоос дээш буюу хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байна.	1	125,499.0	-	-	1	125,499.0	-	-	-	-	-	-
Гүйцэтгэгч компани ажлаа дуусгасан ч холбогдох төрийн байгууллагуудаар баталгаажуулах ажлыг	1	8,000.0	-	-	1	8,000.0	-	-	-	-	-	-

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

хамтран зохион байгуулаагүйгэ эс уг ажил нь хугацаандаа хэрэгжээгүй байна.												
Тайлант хугацаанд зохион байгуулсан 3 удаагийн тендерт тус байгууллагын захирлын тушаалаар баталсан "Үнэлгээний хороо"-ны 2 гишүүн нь тайлант хугацаанд зарласан тендер шалгаруулалтад оролцсон эсэх нь ирүүлсэн баримтаар нотлогдохгүй байна.	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	5	236,875.7	2	103,376.6	3	133,499.1			-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд Шилэн дансны цахим системд 170 мэдээлэл оруулахаас 16 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 46 ДДА-2025/013/НА-СТА-04ӨҮГ Чойбалсан хот
А1170308

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, МУЕА-ын 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал"-ын 3.12-т заасны дагуу "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ нь "Санхүүгийн бодлогын баримт бичиг"-ийг боловсруулахаар "Эвиденсе аудит" ХХК-тай 9.6 сая төгрөгийн гэрээ байгуулан 4.8 сая төгрөгийг 2022 оны 03 дугаар сарын 01-нд урьдчилан шилжүүлсэн байна. Тус газрын удирдлага нь гэрээгээр 2022 оны 12 дугаар сарын 31-нд дуусах уг ажлын хэрэгжилтэд хяналт тавин, үр дүнг тооцоогүй, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 43 дугаар зүйлийн 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдээдлийг тооцсон байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Урьдчилж төлсөн зардалд олгосон 4,800,000 /Дөрвөн сая найман зуун мянган/ төгрөгийг аймгийн Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Б.Алтансүх, ерөнхий нягтлан бодогч Д.Ариунзаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

АУДИТОР  Б.ОДХҮҮ



011050388



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 60 А/160305
ЮСА-2025/013/НА-СТА-ОНӨТҮГ Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрлэн сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх 150.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Уг өр төлбөр нь орон сууцны айл өрх, орон сууцанд байрлах ААНБ-аас 2023, 2024 онд хураан авсан хог тээвэрлэлтийн төлбөрийг Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ, Дорнод НАА ОНӨААТҮГ, Хэрлэн сумын ЗДТГ-ын хооронд байгуулсан гэрээний дагуу Хэрлэн сумын төсвийн дансанд шилжүүлээгүйтэй холбоотой үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", байгууллага хооронд байгуулсан гэрээний 2.3 дахь "Дорнод НАА ОНӨААТҮГ нь хог тээвэрлэлтийн тухайн сард төвлөрүүлсэн орлогын 20 хувийг өөрийн байгууллагад үлдээн, 80 хувийг дараа сарын ажлын 10 хоногт багтаан Хэрлэн сумын төсвийн орлогын дансанд шилжүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хэрлэн сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх ёстой 98,576,627.53 /ерэн найман сая таван зуун далан зургаан мянга зургаан зуун хорин долоон төгрөг тавин гурван мөнгө/ төгрөгийг Хэрлэн сумын төсвийн орлогын 100071400947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Дорнод Нийтийн Аж Ахуй” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал Г.Амарбаясгалан, нягтлан бодогч Д.Ариунзаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 01/190 А/160305
204-2025/013/НА-СТА-ОНЧГ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд зохион байгуулсан 3 удаагийн тендэрт тус байгууллагын захирлын тушаалаар баталсан үнэлгээний хорооны 2 гишүүн нь тайлант хугацаанд зарласан тендер шалгаруулалтад оролцсон эсэх нь ирүүлсэн баримтаар нотлогдохгүй байна. Үүнд: Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг баталгаажуулаагүй, Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна", 51.3-т "Үнэлгээний хороо нийт гишүүний дөрөвний гурваас багагүй тооны гишүүний ирцтэй хуралдсанаар хурлыг хүчинтэйд тооцно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал Г.Амарбаясгалан, нягтлан бодогч Д.Ариунзаяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *И.СЭМЖИДМАА*
АХЛАХ АУДИТОР *Д.НАРМАНДАХ*



2125040560



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 02/191 А/116.03.05

Чойбалсан хот

БОН-2025/013/НА-СТА-ОНӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


"Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил"-ыг хийлгэхээр гүйцэтгэгч компанитай 2023 оны 10 дугаар сарын 26-нд дуусгах гэрээ байгуулан 8.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна. Гүйцэтгэгч компани ажлаа дуусгасан ч холбогдох төрийн байгууллагуудаар баталгаажуулах ажлыг хамтран зохион байгуулаагүйгээс уг ажил нь хугацаандаа хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээт ажлыг дуусгуулах арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал Г.Амарбаясгалан, нягтлан бодогч Д.Ариунзаяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН МЕНЕЖЕР *И.СЭМЖИДМАА*
АХЛАХ АУДИТОР *Д.НАРМАНДАХ*



2125040557